

## АУДИТЫН ҮР ДҮН

Терийн аудитын байгууллагын дэвшүүлсэн зорилт аймаг, орон нутгийн орлогын бүрдүүлэлт, терийн болон төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж хүргүүлж төлбөр, зөрчлийг барагдуулах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх замаар терийн байгууллагын үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө нөөц боломжийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх терийн үйлчилгээний чанар хүртээмж, хариуцлагын механизмыг сайжруулах, аймгийн ИТХ, Засаг даргад зөвлөх, бодитой үнэн зөв мэдээллээр хангах зэрэгт аудитын байгууллага үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж үйл ажиллагааны үр дүнгийн статистик үндсэн гол үзүүлэлтүүдэд зарим ахиц өсөлт гарсан дүнтэй байна.

**Аудитын зөвлөмжөөр** 2015 оныэхний хагас жилд шинээр бүртгэгдсэн 795 зөвлөмж өгсний 84.15 хувийг санхүүгийн тайлангийн аудит, 1.38 хувийг гүйцэтгэлийн аудит, 14.46 хувийг бусад аудит эзэлж нийт зөвлөмжийн 608 буюу 76.48 хувийг хэрэгжүүлж, үлдэх 187 буюу 23.52 хувь хэрэгжих шатандаа хугацаа болоогүй байна.

Тайлант онд аудитын зөвлөмжийн 30.94 хувь нь арвилан хэмнэлттэй, 20.12 хувь нь үр ашгийг дээшлүүлэх, 19.26 хувь нь үр нөлөөг сайжруулах, 20.24 хувь нь дотоодын хяналтыг сайжруулах, 9.44 хувь нь бусад асуудалд чиглэгджээ.

**Акт, албан шаардлага** нэгдсэн болон захиалга, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө, иргэдийн санал хүсэлтийн дагуу гүйцэтгэлийн болон нийцлийн, санхүүгийн бусад аудитаар нийт 218 акт, албан шаардлага бичиж 4361.0 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 92 актаар 90.6 сая төгрөгийн төлбөр илрүүлсний 32.7 сая төгрөгийг барагдуулж улс, орон нутгийн орлого, тусгай зориулалтын сан, төсөл хөтөлбөрийн дансанд оруулж, мөн ажил сайжруулах алдаа зөрчлийг арилгуулахаар 4270.4 сая төгрөгтэй холбоотой 126 албан шаардлага хүргүүлсний 2090.4 сая төгрөгийг хэрэгжүүлж 2180.0 сая төгрөг нь хэрэгжих шатандаа хугацаа болоогүй байна.

**Үр өгөөж:** Гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлан, нийцлийн болон гүйцэтгэлийн аудит, судалгаа шинжилгээний ажлын үр дүнд нийт 3975.9 сая төгрөгийн үр өгөөжийг тооцсоноос аудитын газрын бий болгосон 88.74 хувь буюу 3528.2, тухайн байгууллагын хүлээн зөвшөөрсөн үр өгөөж 11.26 хувь буюу 447.7 сая төгрөгийн үр өгөөж бий болгосон байна.

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, зээл тусламж, төсөл хөтөлбөр, иргэдийн санал гомдолтой холбогдолтой, хөрөнгө үрэгдүүлсэн, шамшигдуулсан байж болзошгүй 16 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар, Терийн аудитын тухай хуулийн дагуу хууль, хяналтын байгууллагаар шалгуулахаар 4 асуудал шилжүүлэн шалгуулж байна.

# АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР